


УРГААГАА ХАНАХ



БАРАА НИЙЛҮҮЛЭХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Төслийн нэр: Зорилтот бүлгийн иргэдэд гэр худалдан авах
Төслийн дугаар: ОРАЖСЗДТГ/202001024

Орхон аймаг
2020 он

Нэг. ЦАХИМ ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Тендер шалгаруулалтын нэр: **Зорилтот бүлгийн иргэдэд гэр худалдан авах**
Тендер шалгаруулалтын дугаар: **ОРАЖСЗДТГ/202001024**
Огноо: **2020 оны 01-дүгээр сарын 30-ны өдөр**

Жаргалант сумын ЗДТГазар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос Жаргалант сумын Зорилтот бүлгийн иргэдэд гэр худалдан авах тухай ЦАХИМ үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулинд нийцүүлэн тендерийн баримт бичигт тодорхойлсон журам болон Харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгоно.

Энэхүү харьцуулалтын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа тул (www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу.

Тендерийг илгээхийн өмнө 30000 /гучин мянган/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна.

Үнийн санал нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна

Үнийн саналыг **2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 09 цаг 00 минут**-аас өмнө www.tender.gov.mn сайтаар орж өөрийн аж ахуй нэгжийн цахим гарын үсэг, хувийн нууцлалын кодоор нэвтэрч www.tender.gov.mn сайтаар дамжуулан цахимаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 02 дугаар сарын 07-ны 09 цаг 30 минутад Жаргалант сумын ЗДТГ-ын Хурлын зааланд** нээнэ.

Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Орхон аймгийн Жаргалант сумын ЗДТГ
Нутгийн удирдлагын ордон
Утас:70397202

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. Тендерийн иж бүрдэл
 - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

Үнийн санал; /маягтын дагуу/
Нийлүүлэлтийн хуваарь;
Улсын бүртгэлийн гэрчилгээний эхийг скайнердаж ирүүлэх
Компаний танилцуулга
2018 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт
Татварын ерөнхий газрын www.e-tax.mta.mn сайтыг ашиглан цахим тодорхойлолт ирүүлэх-Тодорхойлолт нь тендер зарлагдсан хугацаанаас хойш авсан байх шаардлагатай бөгөөд тухайн тендер нээсэн өдрийн байдлаар өр, төлбөргүй байна. Ирүүлсэн татварын тодорхойлолтын хуудасны доод хэсэгт байрлах тоо, тэмдэгт орсон 36 оронтой нууц дугаарыг гаргацтай байхаар ирүүлэхийг анхаарна уу.Татварын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас тендер нээсэн өдрийн байдлаар татварын өр, төлбөрийн талаарх мэдээллийг шалгана. Тендер нээсэн өдрөөр татварын өртэй байвал шууд татгалзана
.НД-ын тодорхойлолт/татвар төлсөн эсэх/ эх хувийг скайнердаж ирүүлэх
Чадварын мэдээлэл /гүйцэтгэсэн ажлын гэрээ, актын хуулбар/ болон бусад баримт бичиг ирүүлэх
Шүүхийн тодорхойлолт
Захирлын цахим иргэний үнэмлэх эх хувиараа скайнердаж ирүүлэх
Тендерт оролцогчийг төлөөлөлж итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсэг зурах бол төлөөлөгч этгээдийн итгэмжлэл, итгэмжлэгчийн иргэний үнэмлэх эх хувиас ирүүлэх
Чадварын мэдээлэл: Өмнөх 2 жил буюу 2017, 2018 онд нийлүүлсэн барааны гэрээ, гэрээг дүгнэсэн акт болон захиалагч, ашиглагч байгууллагуудын тодорхойлолтыг ирүүлнэ. **Захиалагчийн байгууллагын тодорхойлолт:** Өмнөх гэрээг хэрхэн гүйцэтгэсэн, үр дүнгийн талаар өмнөх бүх Захиалагчийн тодорхойлолтыг албан бичгээр, эх хувиар ирүүлнэ.

Ашиглагч байгууллагын тодорхойлолт: Нийлүүлсэн тоног төхөөрөмжийн чанар, одоогийн ашиглалтын талаархи мэдээллийг ашиглагч байгууллага бүрээс албан бичгээр, эх хувиар ирүүлнэ.

Нийлүүлэхээр санал болгож буй автомашины техникийн тодорхойлолтыг захиалагчийн шаардлагаыг харьцуулж ирүүлэх

Жич: Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцэхийг зүйл, заалт бүрээр нотлон харуулсан тайлбар, эсхүл тус тодорхойлолтын аль нэг зүйл заалтыг орхигдуулсан, зөрсөн боловч захиалагчийн тогтоосон техникийн тодорхойлолтын шаардлагад дүйцэхүйц эсвэл түүнээс илүү шаардлага хангасан гэдгийг захиалагчид нотлон харуулна.

1. Нийлүүлэх барааны зургийг өнгөтөөр, харагдах байдал бүрээр бүрэн тодоор ирүүлнэ.
2. Мөн тендерт оролцогч нь: Захиалагч байгууллага харьяа татварын байгууллага, эрүүл мэнд нийгмийн даатгалын хэлтэс, захиргааны хэргийн анхан шатны шүүх, шүүхийн шийдвэх гүйцэтгэх газар, харилцагч банк болон бусад холбогдох байгууллагуудаас тендертэй холбоотой асуудлаар тодорхойлолт авахад татгалзах зүйлгүй гэсэн албан мэдэгдлийг баталгаажуулан эх хувиар ирүүлэх/аль нэгийг орхигдуулсан тохиолдолд татгалзах үндэслэл болно.
3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.1-т заасан нөхцөл үүсээгүй тухай нотлох баримтуудыг ирүүлэх
4. Баталгаат хугацаа олгох албан бичиг ирүүлэх /2 жилээс багагүй байх/
5. Тендерт оролцогч нь уг ажлын техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах этгээдэд нэгдмэл сонирхолтой эсэх талаар мэдэгдэл эх хувиар ирүүлэх
6. Тендерийн баримт бичгийн гэрээний ерөнхий тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл эх хувиар ирүүлэх
7. Тендерт оролцогчийн ирүүлсэн саналыг олон нийтэд мэдээллэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл хүргүүлэх
8. Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ болон хугацаанд багтаан чанарын шаардлага хангасан барааг захиалагчид нийлүүлэх баталгааг бичгээр гаргаж ирүүлэх

Дээрхи тодорхойлолтуудыг тендер зарлагдсан өдрөөс хойш авсан байх шаардлагатай. Өмнө нь авч ирүүлсэн тодорхойлолтыг үнэлгээнд харгалзан үзэхгүйг анхаарна уу.

- | | |
|---|--|
| 4. Тогтмол үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | <p>5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.</p> <p>5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.</p> |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |
| 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх | <p>7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.</p> <p>7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.</p> <p>7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.</p> |
| 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл | 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна. |

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Үнийн санал; /маягтын дагуу/ Нийлүүлэлтийн хуваарь; Улсын бүртгэлийн гэрчилгээний эхийг скайнердаж ирүүлэх Компаний танилцуулга 2018 оны санхүүгийн тайлан,аудитын дүгнэлт Татварын ерөнхий газрын www.e-tax.mta.mn сайтыг ашиглан цахим тодорхойлолт ирүүлэх-Тодорхойлолт нь тендер зарлагдсан хугацаанаас хойш авсан байх шаардлагатай бөгөөд тухайн тендер нээсэн өдрийн байдлаар өр, төлбөргүй байна. Ирүүлсэн татварын тодорхойлолтын хуудасны доод хэсэгт байрлах тоо, тэмдэгт орсон 36 оронтой нууц дугаарыг гаргацтай байхаар ирүүлэхийг анхаарна уу.Татварын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас тендер нээсэн өдрийн байдлаар татварын өр, төлбөрийн талаарх мэдээллийг шалгана. Тендер нээсэн өдрөөр татварын өртэй байвал шууд татгалзана .НД-ын тодорхойлолт/татвар төлсөн эсэх/ эх хувийг скайнердаж ирүүлэх Чадварын мэдээлэл /гүйцэтгэсэн ажлын гэрээ, актын хуулбар/ болон бусад баримт бичиг ирүүлэх Шүүхийн тодорхойлолт Захирлын цахим иргэний үнэмлэх эх хувиараа скайнердаж ирүүлэх Тендерт оролцогчийг төлөөлөлж итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсэг зурах бол төлөөлөгч этгээдийн итгэмжлэл, итгэмжлэгчийн иргэний үнэмлэх эх хувиас ирүүлэх Чадварын мэдээлэл: Өмнөх 2 жил буюу 2017, 2018 онд нийлүүлсэн барааны гэрээ, гэрээг дүгнэсэн акт болон захиалагч, ашиглагч байгууллагуудын тодорхойлолтыг ирүүлнэ. Захиалагчийн байгууллагын тодорхойлолт: Өмнөх гэрээг хэрхэн гүйцэтгэсэн, үр дүнгийн талаар өмнөх бүх Захиалагчийн тодорхойлолтыг албан бичгээр, эх хувиар ирүүлнэ. Ашиглагч байгууллагын тодорхойлолт: Нийлүүлсэн тоног төхөөрөмжийн чанар, одоогийн ашиглалтын талаархи мэдээллийг ашиглагч байгууллага бүрээс албан бичгээр, эх хувиар ирүүлнэ. Нийлүүлэхээр санал болгож буй гэрийн техникийн тодорхойлолтыг захиалагчийн шаардлагаыг харьцуулж ирүүлэх Жич: Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцэхийг зүйл, заалт бүрээр нотлон харуулсан тайлбар, эсхүл тус тодорхойлолтын аль нэг зүйл заалтыг орхигдуулсан, зөрсөн боловч захиалагчийн тогтоосон техникийн тодорхойлолтын шаардлагад дүйцэхүйц эсвэл</p>

	<p>түүнээс илүү шаардлага хангасан гэдгийг захиалагчид нотлон харуулна.</p> <p>9. Нийлүүлэх барааны зургийг өнгөтөөр, харагдах байдал бүрээр бүрэн тодоор ирүүлнэ.</p> <p>10. Мөн тендерт оролцогч нь: Захиалагч байгууллага харьяа татварын байгууллага, эрүүл мэнд нийгмийн даатгалын хэлтэс, захиргааны хэргийн анхан шатны шүүх, шүүхийн шийдвэх гүйцэтгэх газар, харилцагч банк болон бусад холбогдох байгууллагуудаас тендертэй холбоотой асуудлаар тодорхойлолт авахад татгалзах зүйлгүй гэсэн албан мэдэгдлийг баталгаажуулан эх хувиар ирүүлэх/аль нэгийг орхигдуулсан тохиолдолд татгалзах үндэслэл болно.</p> <p>11. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.1-т заасан нөхцөл үүсээгүй тухай нотлох баримтуудыг ирүүлэх</p> <p>12. Баталгаат хугацаа олгох албан бичиг ирүүлэх /2 жилээс багагүй байх/</p> <p>13. Тендерт оролцогч нь уг ажлын техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах этгээдэд нэгдмэл сонирхолтой эсэх талаар мэдэгдэл эх хувиар ирүүлэх</p> <p>14. Тендерийн баримт бичгийн гэрээний ерөнхий тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл эх хувиар ирүүлэх</p> <p>15. Тендерт оролцогчийн ирүүлсэн саналыг олон нийтэд мэдээллэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл хүргүүлэх</p> <p>16. Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ болон хугацаанд багтаан чанарын шаардлага хангасан барааг захиалагчид нийлүүлэх баталгааг бичгээр гаргаж ирүүлэх</p> <p>Дээрхи тодорхойлолтуудыг тендер зарлагдсан өдрөөс хойш авсан байх шаардлагатай. Өмнө нь авч ирүүлсэн тодорхойлолтыг үнэлгээнд харгалзан үзэхгүйг анхаарна уу.</p>
<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Тендер хүлээж авах эцсийн хугацаа нь Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn) –ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй.</p> <p>Огноо: 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдөр Цаг: 09 цаг 00 минут</p>
<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд: Байшин, гудамжны нэр: Орхон аймгийн Жаргалант сумын ЗДТГ, Нутгийн Удирдлагын ордон Давхар болон ерөөний дугаар: Жаргалант сумын ЗДТГ, Хурлын танхим Аймаг, хот: Орхон аймаг, Жаргалант сум</p>

	Улс: Монгол Улс Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: Огноо: 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдөр Цаг: 09 цаг 30 минут
ТӨӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: багцгүй.

БАТЛАВ:

ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА *Т. Энхжаргал* Т.ЭНХЖАРГАЛ

Техникийн тодорхойлолт

1. **Барааны тодорхойлолт:** Нийлүүлэгдэх бараа нь дор дурьдсан техникийн тодорхойлолт, үзүүлэлт, тоо ширхэг хангасан байна.

2. **Баглаа, боодол:** Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодолыг стандартын дагуу хийж эцсийн цэгт хүргэнэ. Түүнээс гарах бүх эрсдлийн нийлүүлэгч хариуцна.

3. **Шалгалт, туршилт:** Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч, эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, туршилт хийх эрхтэй. Шалгалт туршилтыг барааг хүргэх газар буюу нийлүүлэх эцсийн цэгт явуулна. Шалгалт, туршилтаар бараа нь техникийн тодорхойлолтыг хангаагүй тохиолдолд захиалагч тус бараанаас татгалзах эрхтэй ба нийлүүлэгч тус барааг үнэ төлбөргүй солих эсвэл техникийн тодорхойлолттой нийцүүлэх бүхий л арга хэмжээ авна.

№	Бараа материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Тавигдах шаардлага, техникийн тодрохойлолт
1	Монгол гэр	Ширхэг	18	1.Гэрийн тооно- Модон чанартай, хээтэй будагтай 2. Багана- модон чанартай, хээтэй, будагтай 3.Хаалга- модон чанартай, хээтэй, будагтай 3 хавтастай 4.Хана 15 толгой, 5 ханатай, чанартай, сайн чанарын боолттой уг гэрт хүрэлцэхүйц байх 5.Унь- 81 ширхэгтэй, чанартай хээтэй, будагтай, уг гэрт бүрэн хүрэлцэхүйц байх 6.Эсгий дээвэр- 2 ширхэгтэй, сайн чанарын монгол эсгий, уг гэрт бүрэн хүрэлцэхүйц 7.Эсгий туурга – 4 ширхэгтэй, сайн чанарын монгол эсгий, уг гэрт бүрэн хүрэлцэхүйц 8.Дотуур цагаан дээвэр- сайн чанарын цагаан даавуу, уг гэрт бүрэн хүрэлцэхүйц 9.Гадуур цагаан бүрээс- сайн чанарын цагаан даавуу, уг гэрт бүрэн хүрэлцэхүйц 10.Эсгий өрх- сайн чанарын монгол эсгий цагаан даавуугаар, уг гэрт бүрэн хүрэлцэхүйц 11.Дотор хөшиг- сайн чанарын материалаар хийгдсэн, уг гэрт бүрэн хүрэлцэхүйц байх 12.Оосор, буч, гадна дотор бүслүүр- иж бүрдэл сайн чанарын, уг гэрт бүрэн хүрэлцэхүйц байх

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
			Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэх эгчийн санал болгосон хугацаа
1	2	5	6	7	8
Монгол гэр	- Техникийн тодорхойлолтонд тавьсан шаардлагыг хангасан байх	Орхон аймгийн Жаргалант сумын ЗДТГ	7 хоног	хүсэлт тавьснаас хойш 30 хоног	Нийлүүлэх эгч санал болгоно.

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

Жаргалант сумын Засаг даргын Тамгын дарга Т.Энхжаргал

_____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойл олт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фа кс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [1] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн |

- оногдуулах** бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
- 10. Үүргээ биелүүлээг үй-гээс гэрээг цуцлах** 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
- 11. Маргааныг шийдвэрлэх** 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших (ГЕН – 1)** а. Барааг хүлээн авах комисс шалгаж актаар хүлээн авна.
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)** а. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- 3. Баталгаат засвар (ГЕН-5)** а. Баталгаат засварын тусгай шаардлага. /Компани санал болгоно. Баталгаат хугацаа 1 жилээс багагүй байх.
- 4. Төлбөр (ГЕН – 7)** а. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:

Гэрээний үнийн дүнгийн **[100]¹** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.

- 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)²**
- а.** Алданги оногдуулах хувь: **[Хоногт гэрээний үнийн дүнгийн 0.1 хувь]**
- Алдангийн нийт дүн: **[Гэрээний үнийн дүнгийн 10 хувь]**

¹Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

² Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ³

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....
хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ___ сарын _____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч _____ нь _____ нэр төрлийн _____

³ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁴;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

⁴ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

